

**“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ОРОН НУТАГТ ХАМААРАХ ЗААЛТЫН АЙМГИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ**

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Биелэлт
1	2	3	4	
Нэг .АТҮХөтөлбөр зорилт 3.3.1.Иргэнийн нийгмийн байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэхдээ баримт, судалгаа, зөвлөмжийг үндэслэн тэдгээрийн бодит оролцоог хангана.				
3.3.1.4. Авлигатай тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ бүхий, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх.	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	-	Хөтөлбөр боловсруулсан байна	Авлигатай тэмцэх газрын фэйж хуудсанд тавигдсан шторк, мэдээ, мэдээллүүдийг сумын фэйж груд-д хуваалцан иргэдэд сурталчилан ажиллаж байна.
3.3.1.5. Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах.	ОНХяналт хэрэгжүүлсэн байгууллагын тоо	-	Төрийн байгууллагууд хэрэгжүүлсэн байна	Олон нийтийн хяналт тавих иргэн, иргэний нийгмийн төлөөллийг сонон шалгаруулж ирүүлэхийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлд санал өгсөн боловч одоогоор ирээгүй байна.
9.2.1. Үндэсний контентыг бүтээж, авлигыг үл тэвчих үзлийг олон нийтэд төлөвшүүлнэ.				
9.2.1.1.Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулан, хамтран ажиллаж, иргэдэд зориулсан нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэх.	Нэвтрүүлгийн тоо	-	2 доошгүй нэвтрүүлэг бэлтгэсэн байна	-
9.2.1.2. Орон нутгийн олны танил хүмүүсээр шударга ёсны чиглэлээр нөлөөллийн постер, контент бэлтгэн түгээх.	Бэлтгэсэн контентын тоо	-	2 доошгүй контент, 10 доошгүй постер бэлтгэсэн байна	-
9.2.2. Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэх соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, мэдээлэл солилцох сувгийг хөгжүүлнэ.				

9.2.2.1.Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр соёл, урлагийн арга хэмжээг зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах.	Хамрагдсан хүний тоо	-	300	Авлигатай тэмцэх газраас болон амийгийн ЗДТГ-аас гаргасан постер, контентуудыг сумынхаа фэйж хуудсуудаар хувцаалцан сурталчилсан.
9.2.2.2.Орон нутагт зохион байгуулагдаж буй спортын тэмцээн уралдааны үеэр авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр сурталчилгаа хийх.	Зохион байгуулсан үйл ажиллагаа	-	5	Хийгдээгүй байна.
9.3.3. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд игэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.				
9.3.1.Насан туршийн боловсролоор дамжуулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцуулах, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх “Тэвчье, сэргийлье” сургалт, сурталчилгаа, нөлөөллийн аяныг зохион байгуулах	Хамрагдсан иргэдийн тоо	-	10.000	Авто тээврийн хяналтын үзлэг, оношилгооны үеэр 156 иргэнд авлигыг мэдээллье 110 утсыг сурталчилж ажилласан.
9.4.1. Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэх ёс зүй, ёс суртахууны зөв төлөвшил олгоход чиглэсэн сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг насны ангилал, орчин үеийн чиг хандлагад нийцсэн байдлаар судалгаанд тулгуурлан боловсруулна.				
9.4.1.1.Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэх ёс зүй, ёс суртахууны зөв төлөвшил олгоход чиглэсэн сургалт, нөлөөллийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.	Нийт сурагчдын эзлэх хувь	90.0	100.0	ЕБС-ийн Нийгмийн ажилтан 3.Нямбат, Хүүхэд, Гэр бүлийн нийгмийн ажилтан О.Төрболд нартай хамтран ЕБС-ийн ахлах, дунд ангийн сурагчид, Дотуур байрны сурагчдад “Сурагчийн ёс зүйн дүрэм”, “Хувь хүний төлөвшил” сэдвээр давхардсан тоогоор 175 хүүхдэд сургалт, хэлэлцүүлэг хийсэн.ЕБС-ийн 10-12 дугаарын ангийн сурагчдад авлига гэж юу, иргэн бидний оролцоо сэдвээр сургалт зохион байгуулж ажилласан.Нийт 42 хүүхэд хамрагдсан.
9.4.1.2.Хүүхдийг номоор дамжуулан төлөвшүүлэх зорилгоор “Номын сан-Хөгжлийн орчин” үйл ажиллагааг зохион байгуулах.	Зохион байгуулсан ажиллагааны хэрэгжилтээр	-	2	Соёлын төвийн номын сангаас ЕБС-ийн сурагчдын дунд номын баяр арга хэмжээг зохион байгуулж 14 хоногийн ном унших аяныг зарлан 2 сурагчийг шалгаруулан тус бүр 50000 төгрөгөөр шагнаж урамшуулсан.

9.4.1.3.Хүүхдийг хөдөлмөрт сургах, хамтарч ажиллах чадвар эзэмшүүлэх зорилгоор “Хөдөлмөр зуслан” төслийг үргэлжлүүлэх.	Хөдөлмөр зуслан ажиллуулсан сургуулийн тоогоор	2	2	-
9.4.2. Хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалтын түвшинд стандарт тогтоох холбогдох зохицуулалтыг бий болгоно.				
9.4.2.1. Хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалт бий болгох.	ээрэг контент, шторкны тоо	-	3	-
9.4.2.2. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, нөлөөллийн үйл ажиллагаа, аян зохион байгуулах.	Арга хэмжээ, аяны тоо	3	4	Хүүхэд хамгааллын хамтарсан багаас ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдад - Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, - Насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх - Электрон тамхины хор нөлөө - Хорт зуршил гэж юу вэ? Сэдвүүдээр танхимын сургалт хийж давхардан тоогоор 280 гаруй сурагчдыг хамруулсан. Мөн Үеийн тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх “Найз байя” нөлөөллийн аяныг сарын хугацаатай зохион байгуулж, тус аяны хүрээнд: - “Найз байя” рийлийн уралдаан - “Үе тэнгийн дээрэлхэлт” сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.
9.4.2.3. Цахим орчинд хүүхэд, гэр бүлийн зүй зохистой харилцааны талаарх мэдээллийг түгээж гэр бүлд ээлтэй бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх.	Контент Постер, подкаст шторкын тоо	10	12	Хүүхэд хамгааллын хамтарсан багаас Эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, гэр бүлийн боловсрол олгох зорилгоор - Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга - Гэр бүл төлөвлөлт, гэрлэлт - Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан харилцах зөвлөмж

				- Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж - Хүүхэд гэр бүлээсээ үлгэрлэж суралцдаг зан үйл - Эцэг эхийн харилцааны хэв шинж хүүхдийн зан төлөв, сэтгэл зүйн байдалд шууд нөлөөлөх нь сэдвүүдээр нийт 16 постер, шторк бэлтгэн цахим орчинд түгээсэн.
9.5.2. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилна.				
9.5.2.1.Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах.	Зохион байгуулсан үйл ажиллагаа	-	500	Иргэдэд АТГ-ын 110 утсыг сурталчилан ажиллаж байна. ЗДТГазар болон ЭМТөвд юнител ХХК-ны байгууллагын дуудлага шилжүүлдэг дугаарыг авч ашиглаж байна. ЗДТГ-70327788 утсаар гомдол мэдээлэл хүлээж авахаас гадна нэн шаардлагатай төрийн үйлчилгээний талаар мэдээлэл авах албан хаагчдын дугаарыг оруулж өгсөн.
10.2.3.1. Гамшгаас хамгаалах болон онц байдлын үеийн хандив, тусламжийг бүртгэх, зарцуулалтыг ил тод болгох , хяналт тавих олон нийтэд нээлттэй цахим системийг нэвтрүүлнэ.				
10.2.4.1.Хандивыг төрийн сангийн дансанд төвлөрүүлж, зарцуулалтыг тухай бүр олон нийтэд ил тод тайлагнах.	Ил тод болгосон мэдээллийн тоо	-	Тухай бүр байршуулсан байна.	Хүнд өвчтой 2 иргэнд хандив цуглуулах аян, арга хэмжээ болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгосон хандив, хүүхэд баярлуулах арга хэмжээнд Нэг бэлэг-Нэг инээмсэглэл аяны хүрээнд цугласан бэлгүүд ийн талаар Тамгын газрын фэйж хуудсаар нээлттэй ил тод мэдээллийг байршуулан ажилласан.
Хоёр. Бусад. Орон нутгийн төрийн байгууллага, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлнэ.				
2.1.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сум, агентлаг, төсөвт байгууллагуудын удирдах ажилтнуудад АТГ-	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	200 удирдах ажилтан	250 доошгүй Төсвийн шууд захирагч нарыг	Авлига ашиг, сонирголоос ангид байх талаар төрийн байгууллагуудын албан хаагч нарт байгууллагын хурал дээр нь мэдэгдэл, тайлбар гаргах, ХАСУМ,

тай хамтран сургалт, уулзалт зохион байгуулах.		хамрагдсан	хамруулсан байна.	ХАСХОМ гаргах талаар сургалтыг зохион байгуулан ажилласан. Нийт 56 албан хаагч хамрагдав.
2.2.Авлигатай тэмцэх газраас зарласан аян нөлөөллийн үйл ажиллагаатай уялдуулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй өдөрлөг зохион байгуулах.	Зохион байгуулсан арга хэмжээ	“Нэгдье аян”	“Нээлттэй өдөрлөг” Зохион байгуулна.	Хийгдээгүй.
2.3. Төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хороодтой хамтран ажиллаж, мэдээлэл солилцон, ёс зүйн зөрчил гарч буй байгууллагуудад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах.	Шинэчлэн байгуулагдсан ёс зүйн дэд хорооны тоо	-	42	Төрийн байгууллагуудын ёс зүйн дэд хороодод ЗДТГ-ын ёс зүйн дэд хорооноос 2 удаагийн сургалт арга хэмжээг зохион байгуулав. ЗДТГ-ын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон хөдөлмөрийн тухай хууль, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр сургалт зохион байгуулав. Нийт 42 албан хаагч хамрагдав

-oOo-

